

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Ярилцлага өгөгчийн нэр	Далхжав гуайн ээж	Дугаар	L078
Оршин суугаа аймаг	Хэнтий	Оршин суугаа сум	Батноров сумын Идэрмэг баг
Төрсөн газар	Батноров сум	Төрсөн он	1924
Ажил мэргэжил	өндөр настан		
Лам байсан эсэх, Шавилан сууж байсан сүм хийд	Сэргэлэн гүний хийд буюу Шадавчойнхорлин хийд	Сүм хийдийн дугаар	ХЭБВ 106
Одоогийн сүм хийд		Сүм хийдийн дугаар	
Ярилцлага авсан он сар өдөр	2007 оны 7-р сарын 18	Ярилцлага авсан хүн	Ж.Одгарьд

Хэнтий аймаг Батноров сумын Шадавчойнхорлин хийд

Та Сэргэлэн гүний хийдийн тухай мэдэх зүйлээ ярьж өгөөч?

Сэргэлэн гүний хийдийн тууринаас би нэг бурхан, ээж нэг зэс таваг олж байсан. Тэр бурхан нь их хөөрхөн. Ямар сайндаа тэр бөөрөнхий бурхан загал бурхан хоёрыг хөөрхөн бурхан гэж ярьдаг. Намайг 14-тэй байхад л байхгүй болсон юм даа.

-Та хэдэн онд төрсөн бэ?

1924 онд.

- Сэргэлэн гүний хийд хэдэн дугантай байсан бэ?

Нэг дугантай, хоёр байшинтай байсан. Дуганыхаа хоёр талд байсан. Нэг нь шүтээний дуган. Нөгөөхийг нь мартчихаж. Зүүн талд нь жас байсан. Хоол унд, цав манзаа хийдэг байсан газар. Баруун урдуур хүрд байсан.

-Хэр олон ламтай байсан бэ?

Мэдэхгүй. Миний ээжийн ах нэг өвгөн лам байдаг байсан. Би тэр хүнд цайны сүүг нь шүдлэн үхэр унаж аваачиж өгдөг байсан. Би 10-аад настай байсан.

-Та мяндагтнуудыг нь мэдэх үү?

Мэдэхгүй.

Гончиг гэлэн гэж нэг өвгөн гэлэн гэж байсан. Их л өндөр настай хүн байсан. Ямар цолтой байсныг мэдэхгүй.

Гэндэн Даа лам гэж байсан. Баруун хойно гэр нь байсан.

-Ямар сахиустай байсан юм бол?

Тэрийг мэдэхгүй. Гол шүтээн нь нэг цагаан дүртэй зандан бурхан байсан.

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Логшир бурхан байсан гэж хэлдэг юм байна лээ. Тэгсэн гол шүтээн нь Говийн Лха гэж хэлж байсан. Шүтээнээ ууланд тавьсан. Тэгээд тэр шүтээн бол энэ ууланд л шингэсэн.

-Сүжигтийн хийд, Бат Өлзийтийн хийдийг мэдэх үү?

Ёстой мэдэхгүй.